

МОНГОЛ ХЭЛНИЙ ГАЗАР, УСНЫ НЭР БҮТЭЭХ ДАГАВРЫН УТГА

Д. Бадамдорж*

Монгол хэлний газар, усны нэрийг оноосон нэр (макротопоним), дэвсгэр нэр (микротопоним) (4:163) гэж хоёр ангилж болно. Оноосон нэр гэдэг бол монгол газар, усны өвөрмөц олон шинжийг танин мэдэж, тусгайлан өгсөн нийтээр мэдэх нэрсийг хэлнэ. Жишээлбэл, Алтай, Хангай, Хэнтэй, Сэлэнгэ, Отгонтэнгэр, Орхон, Онон, Туул гэх мэт. Дэвсгэр нэр гэдэг бол оноосон нэрийн дараа байрладаг ялган тодотгох утгатай, хэлж хэвшсэн, ерийн нэрийг хэлнэ. (1:06) Жишээлбэл, уул, нуруу, толгой, тал, говь, гол, мөрөн, булаг, нуур гэх мэт.

Монгол газар, усны нэрийн оноосон нэр, дэвсгэр нэр хоёрыг хамт хэрэглэж заншсан байна. Тухайлбал, Загастай гол (Баян-Өлгий), Загастай нуур (Дундговь), Загастайн даваа (Завхан) (7:399) гэх мэт. Оноосон нэргүйгээр дэвсгэр нэрийг, дэвсгэр нэргүйгээр оноосон нэрийг ухаж мэдэхэд амаргүй болдог ажээ.

Хэлний дагаврын ба дагаврын бус аргаар монголчууд газар, усны нэрийг бүтээж ирсэн бөгөөд ямар газар, ус болохыг илэрхийлэх тухайлсан хэдэн дагавар буйг бид зүйлчилж, утгын тайлбар бичлээ. Үүнд:

Нэг. Дагаврын аргаар газар, усны нэр бүтээх нь:

Монгол хэлний үгийн сангийн нэгж “бургас” гэх үглэвэр нь “Улиасны язгуурын, голын хөвөөгөөр ургадаг, гулзгар уяхан мөчиртэй, нарийн навчтай, бутлан ургах нэгэн зүйл бут мод.” (5:364) болно. Харин “Бургаст” гэвэл –т дагавар нэмсэн учир, “Бургаст уул. Хангайн нурууны баруун хэсэгт Хар нуураас хойш Галуутын голоос урагш хойд өргөрөгийн 48° 29', зүүн уртрагийн 96° 10'-ын солбицолд орших 2880 м өндөр уул.” (15:30) гэсэн нэр болдог байна. Ийм учраас “бургас”, “Бургаст” хоёр нэр нь ялгаатай болох нь мэдэгдэж байна.

Монгол газар, усны нэр бүтээх энэ мэт дагавар нь:

01. **-аа (-ээ, -оо, -өө).** Үйл үгээс үйлийн байдал, үр дүнг илтгэсэн утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Дав- + аа = даваа: Агийн даваа, Азаргын даваа, Загастайн даваа, Ганцын даваа, зал- + аа = залаа: Бага залаа, Баруун залаа, гүвий- + ээ = гүвээ: Бор гүвээ, Улаан гүвээ, Цагаан гүвээ, овой- + оо = овоо: Алтан овоо, Бага овоо, Бэрх овоо, өвөлж- + өө = өвөлжөө: Их өвөлжөө, Цагаан өвөлжөө, сал- + аа = салаа: Баруун салаа, Дунд салаа, хөш- + өө = хөшөө: Ар хөшөө, Талын хөшөө гэх мэт. Мөн идэвхгүй язгуураас

* МУИС-ийн МХСС-ийн Хэл шинжлэлийн тэнхим

байр байдал заасан газрын нэр үүсгэнэ. Жишээ нь: Хөд- + өө = хөдөө: Азаргын хөдөө, Зостын хөдөө, Онцын хөдөө, Хүйтэний хөдөө, ух- + аа = ухаа: Ажнай ухаа, Зуутын ухаа гэх мэт.

02. **-аа (-ээ).** Үйл үгээс тухайн газар, усны дуу чимээний холбогдолтой утгатай оноосон нэр бүтээнэ. Жишээ нь: Хархир- + аа = Хархираа (Алтайн нурууны салбар, Түргэн уулын урд залгаа болж, зүүн уртрагийн 91⁰ 15', хойд өргөрөгийн 49⁰ 32'-д оршино), хүрхэр- + ээ = хүрхэрээ: Улаан цутгалангийн хүрхэрээ, борги- орги- + оо = боргио (уулын хад асгат газарт буусан голын ус) гэх мэт.

03. **-в.** Идэвхгүй язгуураас газрын овор төрх, өвөрмөц тогтцын утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Ца- в = цав: Алаг цав, Бор цав, Улаан цав, Цагаан цав, сүв: Алагийн сүв, Бичигийн сүв, Монголын сүв, Хадатын сүв, гав: Газарын гав (Завхан), хөв: Ар хөв, Урд хөв, Баруун хөв, Зүүн хөв, дов: Ногоон дов, Өндөр дов, Хөх дов гэх мэт.

04. **-вар (-вар, -вор, -вөр).** Үйл үгээс газрын онцлог шинжийг илтгэсэн дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Хөө- + вөр = хөөвөр: Ар гээзгийн хөөвөр, Баруун хөөвөр, Зүүн хөөвөр, Төгс хөөвөр, Уулз- + вар = Богино уулзвар, Өлийн уулзвар, Шар уулзвар, Эхэн уулзвар гэх мэт.

05. **-вч.** Нэр үгээс газрын хонхор хотгорыг заасан утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Хүзүүвч (Үргэлжилсэн цул нурууны дундах хотгор, нахис, бяцхан хөтөл онь), (6:2742) Зүүвч (нам дор газар, устай зүүвч (Сэлэнгэ, Баруунбүрин), Хүрээ зүүвч (Сэлэнгэ 12:203), Хацавч (Хацар+вч хоёр талаасаа ханан хатавч бүхий хонхор, хотгор газар, Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумд буй.) гэх мэт.

06. **-вь (-би).** Идэвхгүй язгуураас газрын халцгай, өвс ургамал тачир шинжийн утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Говь (ургамал тачир сийрэг, ой мод ба ургамал ус маш ховор, элс хайрган хөрстэй, тарвага нутагладаггүй, хээр тал газар, Баянговь, Галбын говь, Шаргын говь, Долоодойн говь гэх мэт), Говил (Э. Равдан: <<Говил нь “ховол, ховил зэрэг тун ойрхон утгатай бөлгөө. Говилын гол (Булган, Дашинчилэн), Уст ховилын ам (Сэлэнгэ, Түшиг), (12:202-203) гэжээ. Говь, Говил Ховил гэх мэт газрын нэр гарал нэгтэй юм.

07. **-г.** Ихэвчлэн идэвхгүй язгуураас тэгш бус гадаргуут газрын дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Аара- г = Бага аараг, Баян аараг, Үнэгэдийн аараг, Айраг: Баян айраг, Ямаатын айраг, адаг: Гангын адаг, Тээлийн адаг, Хөшөөт адаг, мөнхүү *булаг, зээг, нутаг, өтөг, суваг, судаг, тээг, таг гэх мэт газрын олон дэвсгэр нэр бүтээжээ. Цөөвтөр нэр үгээс газрын овор төрхийг илэрхийлсэн утгатай газар усны нэр бүтээнэ. Жишээ нь: Бөөрөг, дэвсэг, заваг, намаг, сархиаг, дэнжиг гэх мэт. Цөөн үйл үгээс газрын хэлбэр дүрс, овор төрх, зай завсрын утгат газрын дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Хавчи- г = хавчиг: Ар хавчиг, Өвөр хавчиг, Хөх хавчиг, цүнхий- + г = цүнхэг: Зуслан цүнхэг, Дунд цүнхэг, Түвшин цүнхэг, Эхний цүнхэг, Сэрүүн цүнхэг, Хэлтгий цүнхэг гэх мэт. (8:25) гэх мэт.

08. **-га (-г, -го).** Үйл үгээс хад чулуу, устай холбоо бүхий дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Гатал- + га = гаталга: Хайртын гаталга, Хавчиг гаталга гэх мэт, Асга (аса+га- асаж тогтсон чулуу, Цагаан асга, Хүрэн асга гэх мэт), Мөнхүү идэвхгүй язгуураас нам дор, гуу жалгын утгатай нэр бүтээнэ. Жишээ нь: Ганга (Их ганга, Мухарын ганга, Наймын ганга, Нарийн ганга), Нуга (Айдын нуга, Гээг нуга, Хонин нуга, Цацын нуга, Жалга (Борын жалга, Гүн жалга, Нарийн жалга, Уу жалга, Цагаан жалга), Адарга (Баян адарга, Хөх адарга) гэх мэт.

09. – **гай (-гой, -гий)**. Идэвхгүй язгуураас шинж байдал заасан дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Өлгий (Бага-Өлгий, Их-Өлгий, Төмөр-Өлгий), Хавцгай~Хавтгай (Далд хавцгай, Тамчийн хавцгай, Цагаан хавцгай, Нарст хавтгай, Урд хавтгай, Хойд хавтгай), задгай (Гоёотын задгай, Өлзийт задгай, Эхэн задгай), хангай (Архангай, Өвөрхангай, Баянхангай) гэх мэт.

10. – **гал (- гол, - гөл, -хил)**. Идэвхгүй язгуураас томоохон ус, газрын оноосон нэр бүтээнэ. Монгол, Түрэг хэлний хэрэглээтэй дагавар юм. Жишээ нь: Байгал, Хөвсгөл, Хатгал, Зоргол, Тонхил гэх мэт. Ж.Төмөрцэрэн: “Байгал нуурын бай гэдэг нь түрэгээр баян, гал гэгч нь түрэгээр көл буюу күл (нуур) гэсэн үг, өргөлтөт үедээ захирагдан гал болж хувирсан хэрэг юм.” (14:97) гэжээ.

11. – **гар (- гэр, - гор, -гөр)**. Үйл үгээс газрын дээш өргөгдсөн, доош хотойсон овор төрхийг илэрхийлсэн дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Товой- + гор = товгор: Бунгийн товгор, Ногоон товгор, Хацавчийн товгор), Гозгор (Бүргэдийн гозгор, Дулаан гозгор, Шийрийн гозгор), Овгор (Даваатын овгор, Сүүл овгор, Цахиуртын овгор), Шовгор (Нунжийн шовгор, Хавчийн шовгор), Хотгор (Алдарын хотгор, Сүүжийн хотгор, Шар хотгор), *Сөгнөгөр гол гэх мэт.

Э.Равдан “Дэвсгэр нэрийн бүрэлдэхүүнээс үзэхэд “овоо, худаг, өвөлжөө” зэрэг цөөн нэрээс бусад нь бүгд газрын тодорхой биетэд хамаатай дэвсгэр нэр байна. Дэвсгэр нэрийн цэст газрын нэг биетийг хэд хэдэн хувилбараар нэрлэсэн тохиолдол ч цөөнгүй байгааг тэмдэглэвэл зохино. Жишээлбэл, хунх, хунхар, хунхуй, хүнх, хүнхэр, гүдэн, гүрдгэр гэх мэт болно.” (12:29) гэв.

Газрын нэрийн овор төрх заасан –хар (-хор) хувилбар нь - гар (-гэр) дагаврын хувилбар юм.

12. –**д**. Нэр үгээс газрын хэсэг тоот дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Толгой- + д = толгод: Буйрын толгод, Дэлгэрийн толгод, Зах толгод, Хөх толгод, Цагаан толгод, Долоод (тойром, Дорноговь), Долоод (тал, Хэнтий), *Хулд уул (Дорнод) гэх мэт.

13. –**д**. Идэвхгүй язгуураас газрын онцлог байдлыг илтгэсэн дэвсгэр нэр бүтээнэ.. Жишээ нь: Бүр- + д = бүрд: Баян бүрд, Доод бүрд, Дээд бүрд, Шар бүрд, Могойн бүрд гэх мэт.

14. –**даг (-дэг, -дог, -дөг)**. Үйл үгээс хөдөлгөөн, хөдлөлөөр сэтгэж нэрийдсэн, үйлээр дүрсэлсэн утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Өвхий- + дөг = өвхийдөг: (уул, Ховд), Ховд аймгийн Эрдэнэбүрин сумын Өөлдүүдийн газар, усны 1500 гаруй нэрийн дотор “Навч хурдаг, Ямаа байцалдаг, Буурын амны хүн оршуулдаг, Чулуун хөдөлдөг, Дөрөө хавчдаг (Ц.Шагдарсүрэн: “Дөрөө хавчдаг гэдэг нэртэй газар болгон соронзтой байдаг ажээ”. (16:12), Уралдаан тосдог, Ямаа үхдэг, Жамсайн үхдэг, Усан салдаг, Хадаг тавьдаг хад, Ачаа давдаг, Морь барьдаг, Юм дуугардаг, Хөл цухуйдаг, Үүрээ засдаг, Улир хонодог хад, Тураг шивээлдэг, Чоно төрдөг хад, Ёл төрдөг хад, Хурга хашдаг, Эсгий хийдэг, Ямаа авалдагийн мухар, Ямаа ордог үзүүр (8:3-28) гэх мэт цагт нэрийн – даг⁴ дагаварт газрын нэр байгаа нь нэлээд өвөрмөц нэрийдэл болно.

Мөн Улаан болдог, Дэлүүн болдог, Ажигийн сарьдаг, Бүрэнгийн сарьдаг, Хорьдол сарьдаг, Хүйсийн сарьдаг, Ширгэдэг нуур (Увс) гэх мэт газар усны нэрнээ эл дагавар утга ялгасан байна. Э.Равдангийн судалгааны дүнгээс үзэхэд “Монгол газар нутгийн нийт 214805 оноосон нэрийн үгийн санг бүрдүүлсэн 540140 үг...” – ийн дотор барьдаг 16, буудаг 17, тавьдаг 15, давдаг 49, майлдаг 19, саадаг 33, тахидаг 17, төрдөг 59, хавчдаг 23 (10:55) удаа давтагдаж байгаа нь маш сонирхолтой юм. Энд төрдөг гэдэг үг 59 удаа байгаа нь Сав, шим ертөнцийн шүтэлцээний онцлог болно.

15. **-дай (-дэй, -дой, -дөй).** Нэрээс газрын өхөөрдөл утгатай оноосон нэр бүтээнэ. Жишээ нь: Ингэдэй гол (Чита хот), Манхаадай (гол, Хэнтий), Унагадай (уул, Дорнод); Газар, усны толь бичиг, лавлах бичиг зэрэгт одоогоор гарал, бүтцийг нарийвчилан шинжлээгүй Аадай, Аваадай, Авалдай, Аргалдай, Атгалдай, Аялдай, Багдай, Балуудай, Бовдой, Богинодой, Боолдой, Боохолдой, Бугандай, Бужигдай, Бууралдай, Гургалдай, Дашиндай, Зуваадай, Зураадай, Ишгэлдэй, Мондой, Нуухалдай, Өөдөй, Тормоодой, Ухандай, Хашгалдай, Хөхөөдөй, Хургадай, Шовондой, Шовоодой (10:222-259) -аадай, -ндай, -лдай гэх мэт нийлмэл хувилбар бий.

16. **- ж (- жи, - жин).** Идэвхигүй язгуураас өндөрлөг газрын дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Дэн- + ж = Агьтын дэнж, Ар дэнж, Өндөр дэнж, Ойрад аялгуунд “дэнжиг” гэдэг. Бага *хонгорж уул (Өмнөговь), *Хулжи гол (Булган аймаг) гэх мэт.

17. **- й.** Нэр үгээс зарим газар усны өнгийг тодотгосон утгатай оноосон нэр бүтээнэ. Жишээ нь: Хөхү- + й = Хөхүй: Хан хөхүй (Увс аймгийн нутаг дахь 2928 м өндөр уул), Хойд шарай гол (Говь-Алтай), Хан харайн уул (12:359), Шаргай уул (Завхан. Тэлмэн) гэх мэт.

18. **- л.** (- ла, - лэ) Идэвхигүй язгуураас газрын нам, өндөр байдлын утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Бэ- + л = бэл: Зүүн бэл, Өвөр бэл, Ямаатын бэл, Гол (Агьт гол, Баян гол, Завхан гол, Дунд гол), Хавцал (Бага хавцал, Их хавцал, Хуурай хавцал), Хөтөл (Салхит хөтөл, Хөх хөтөл), *тал (Арвайхээрийн тал, Тэрэгтийн тал), *уул (Алаг уул) гэх мэт.

19. **- лаг (- лэг, -лог, -лөг, - лиг).** Нэрээс газар усны шинж илтгэсэн утгат оноосон нэр бүтээнэ. Жишээлбэл: Ангир- + лиг = Ангирлиг нуур (Баян-Өлгий), Цэнгэлиг нуур (Дорнод), Цөмөрлиг уул (Хөвсгөл), Эзэрлиг уул (Баян-Өлгий), Онголиг гол (Хөвсгөл) гэх мэт.

20. **- лан (- лэн, -лон, - лөн).** Үйл үгээс үйлийн үр дүнг үзүүлсэн утгатай газар усны дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Зус- + лан = Зуслан: Өвөр зуслан, Тэсийн зуслан), цутгалан (Улаан цутгалан, Их цутгалан), *Хэрлэн гол (хэрү+лэн гэж үүссэн байж магадгүй) гэх мэт.

21. **- лж.** (-лжин) Нэрээс газрын хэлбэр байдлыг заасан утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Дөрөлж (Агуйтын дөрөлж, Хайрхан дөрөлж, Ханхар дөрөлж), Дөрвөлжин (Бага дөрвөлжин, Цагаан дөрвөлжин) гэх мэт.

22. **- м.** Үйл үгээс үйлийн үр дүнг заасан утгатай газар усны дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Тойром (Алаг тойром, Ахар тойром, Баян тойром, Их тойром), Цөөрөм, Боом (Дунд боом, Урд боом, Эмгэлжийн боом), Угтам уул (Дорнод) гэх мэт. Идэвхигүй язгуураас газрын шинжийг заасан утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Царам (Ар царам, Улаан царам, Хөх царам), Цайдам (Бага цайдам, Их цайдам, Хөшөө цайдам), төхөм (Баян төхөм, Үхэртийн төхөм, Хулгар төхөм) гэх мэт.

23. **- н.** Нэр үгээс газрын хэлбэр, овор, байр, өнгө зэрэг шинжийг илэрхийлсэн дэвсгэр нэрээс шилжсэн оноосон нэр бүтээнэ. Жишээ нь: Тосон, Ханан, Хөндлөн, Алтан гэх мэт.

Мөн нийлмэл нэр үүсгэнэ. Ар ханан, Хойд ханан, Ар хөндлөн, Уст хөндлөн, Тосонцэнгэл, Аваргатосон, Алтан уул гэх мэт.

24. **- н.** Үйл үгээс газрын овор төрхийг илтгэсэн дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Сэрвэн (сэрвий+н-сэрвэн-Идэрийн сэрвэн, Шаргын сэрвэн), Сэртэн (сэртий+н-сэртэн – Ажирхайн сэртэн), Шовон (Устын шовон) гэх мэт.

25. – **най.** Идэвхгүй язгуураас газрын шинжийг илтгэсэн оноосон нэр бүтээнэ. Жишээ нь: Бул^{на}й (Булнайн оргил нь 2600 м өндөр), Зулганай (Өмнөговь, Гурвантэс) гэх мэт.

26. – **р.** Үйл үгээс газрын овор төрх байдал шинжийн утга заасан дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Бэлчир (бэлчи+р, Бор бэлчир, Бумбат бэлчир, Их бэлчир, Улаан бэлчир, Хар бэлчир, Хөх бэлчир), Шаргайн бэлчээр, Цахир (Баянцахир, Их цахир, Талын цахир), Мухар (мухай+р, Ар мухар, Бага мухар, Өвөр мухар), Хонхор (хонхой+р, Төгрөгийн хонхор, Усны хонхор, Цацын хонхор, Шүүт хонхор), Хүнхэр (хүнхий+р, Дээд хүнхэр, Доод хүнхэр), Өндөр (өндий+р, Алаг - Өндөр, Баян Өндөр, Дэлгэр-Өндөр, Улаан-Өндөр), басхүү идэвхгүй язгуураас нам дорын утгатай дэвсгэр нэр бүтээдэг. Жишээ нь: Нуур (Агьт нуур, Хар нуур, Цагаан нуур), Хонхор, Сайр (Ар сайр, Баруун сайр, Тооройн сайр) гэх мэт.

27. – **с (- сун, - сүн).** Идэвхгүй язгуураас газар усны салах салаалах, ширхэглэх утгат дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Ус (Аман ус, Бөөргө ус, Хөтөл ус, Ямаан ус), Элс (Аалзатын элс, Бор элс, Инээдэг элс, Монгол элс, Цагаан элс) гэх мэт.

28. – **т (- тай, -тэй).** Нэр үгээс тухайн сав шим ертөнцийн оршин байгаа юм элбэг дэлбэгийн утга илэрхийлсэн оноосон нэр бүтээнэ. Жишээ нь:

- Тухайн газар усанд амьтан элбэг байгааг илтгэсэн нэр: Үнэгт, Туулайт, Борогч гүүт, Шарга морьт, Хөх морьт, Алаг морьт, Хандгайт, Бугат, Шилүүстэй, Мануулт, *Аргалант уул гэх мэтээр уул усны ойролцоохи амьтны нэрээр нэрлэнэ.
- Өвс ургамлын нэрээр тийм ийм ургамал элбэг байгааг танин мэдэж нэрийдсэн байна. О.Сүхбаатар “Улиастайн гол, Мангирт, Нэрст, Мойлт, Гачуурт, Бургастай, Яргайт, Хустайн нуруу...” (13:23) гэх мэт оноосон нэрс бол мод ургамал, үр жимсийн нэрээр нэрлэсэн болохыг онцлон дурджээ.
- Тухайн газар усанд эрдэс баялаг арвин байгаа онцлогоор нь нэрийдсэн тул баялаг бүхий гэсэн мэдээлэл өгөх ач тустай нэр цөөнгүй бий. Жишээ нь: Эрдэнэт, Уст уул, Зост, Төмөрт уул, Жоншит, Билүүт, Хужирт, Шохойт, Рашаант гэх мэт. Монгол хэлтэн ард түмний газрын нэрнээ – т (-тэ, -то), -са (-сэ, -со) зэрэг дагавар түгээмэл (17:141) байгааг Л.В.Шулунова тэмдэглэжээ.
- Тухайн газрын онцлог дүрс байдал шинжээр нь нэрийдсэн байна. Жишээ нь: Агуйт уул, Асгат уул, Хадат, Галт, Галт нуур, Сэнжит цохио гэх мэт.
- Тухайн газрын түүхэн дурсгалт шинжээр нь нэрлэсэн байна. Жишээ нь: Мааньт, Бичигт тал, Хөшөөт, Бурхант, Тахилт гэх мэт.

29. – **тай (-тэй).** Идэвхгүй язгуураас газрын оноосон нэр бүтээнэ. Монгол, Түрэг, Манж хэлний дундын шинжтэй байна. Жишээ нь: Алтайн нуруу, Хэнтэйн нуруу, Хантайн даваа (Булган аймаг) гэх мэт.

30. – **хай(-хэй).** Үйл үгээс газрын зай хэмжээ, орон зайн утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Тасархай (Ар тасархай, Доод тасархай), Балбархай (Ногоон нуурын балбархай) гэх мэт.

31. – **хан (-хэн, -хон, -хөн).** Нэр үндсээс газар усны өргөмжит оноосон нэр бүтээнэ. Жишээ нь: Хайр- + хан - Хайрхан(Асралт хайрхан, Их хайрхан, Цагаан хайрхан, Баян хайрхан), Божоо- + хон- Божоохон (Сүхбаатар, 1344 м өндөр), *Хөгнө хан, Алтай хан, Хэнтэй хан гэх мэт. Энэ хан бол ирээдүйд дагавар болох шинжтэй байна.

32. – **ц.** Ихэвчлэн үйл үгээс үйлийн үр дүн илтгэсэн утгатай газрын дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Бууц (Талын бууц, Хадатын бууц, Бүлгэм бууц (Ховд, Эрдэнэбүрэн), Хөөвөрийн бууц, Байц (Баруун байц, Их байц, Улаан байц, Хөх байц), Гарц (

Хилэнтийн гарц), Хайц гол (Дорнод), *Хэц (Зээгийн хэц, Могойтын хэц) гэх мэт. Норжин “ Үйлийн хэмжээ байдлыг илтгэх ... бууц, байц ... “ (9:168) гэж –ц дагаврын утгыг тодорхойлсон байна.

33. –цаг (-цэг, -цог, -цөг). Ихэвчлэн идэвхгүй язгуураас газар усны содон шинжийг илэрхийлсэн утгатай дэвсгэр нэр бүтээнэ. Жишээ нь: Молцог (Өмнөговь), Молцог элс, Довцог (Бага довцог, Доод довцог), Дэвцэг (Нүүрэнтийн дэвцэг, Төвийн дэвцэг, Эрэгийн дэвцэг), Мөрөгцөг (Дорноговь), Оорцог (Баруун оорцог, Урд оорцог, Хойд оорцог), Эрэгцэг (Долоодын эрэгцэг, Тарагтын эрэгцэг, Хошуу эрэгцэг), Хангилцаг гол (Увс) гэх мэт. Л.Болд “Эрэгцэг (мөрөн гол, уул сав, ам зэрэг хотгор газар тулгарч, эгц болсон хажуу явцуу газар), Мөрөгцөг (газрын тохойрсон мөгүү эрэгцэг)” (3:88) гэж эл дагаврын утгад гарч байгаа шинэ салаа утгыг тэмдэглэжээ. Энэ дагавар тухайн газрын тогтоц овгор товгор, эгц эрэг байдлыг заахын хамт багын утга бас санагдана. Адаацаг уулын нэрийн –цаг нь оорцог гэх нэрийн адил байж мэднэ.

34. –ч. Нэр үндсээс газрын онцлогийн утгатай оноосон нэр бүтээнэ. Жишээ нь: Богоч (Дунд богоч, Их богоч, Бага богоч, Улаан богоч, Хөх богоч), Үенч гол, Үенчийн хавцал, Хөвч (Ар хөвч), Алтач (Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын хойд нэсэгт орших 1043м өндөр уул), Бодонч гол (зарим үед хүчтэй үерлэж, их шавар элс тууж авчирдаг) (15:24) учир ийм нэр өгсөн бололтой.

35. –ш. Нэр үндсээс газрын шинжийг заасан дэвсгэр, оноосон нэр бүтээнэ. Жишээ нь: Хүүш (Бор булагт хүүш, Бяцхан хүүш, Их хүүш, Модот хүүш, Өндөр хүүш) гэх мэт.

Хоёр. Газар усны нэрийг танин мэдэхүйн утгазүйн үүднээс шинжлэх нь

Монгол туургатан удам газар нутагт нүүдэллэж, нүүдлийн соёл иргэншлийг хүн төрөлхтөний соёлын түүхэнд буй болгожээ. Нүүдэлчид газар, ус бүрийг сайтар танин мэдэж, монголчуудын өвөрмөц сэтгэхүй, сэтгэлгээний нөлөөгөөр доорхи нэр үүсчээ.

1. Баянхангай, байгаль дэлхийгээ шүтэн хүндэтгэх, хайрлан хамгаалах сэтгэлгээгээр олон сайхан нэр хайрласан байна. Хаан (Бүрэнхаан, Батхаан, Дарханхаан, Дэлгэрхаан), Хан (Богд хан, Дулаан хан, Жаргалтхан), Богд (Аж богд, Богд уул, Богдын гол), Тэнгэр (Отгонтэнгэр, Тэнгэр уул, Тэнгэр нуур), Бунхант, Тахилт, Бурханбуудай, Цагаанхайрхан, Их хайрхан гэх мэтээр хаан, хан, богд, тэнгэр, хайрхан гэсэн үгс давтамж бүхий байх бөгөөд монголчуудын уул нуруу тэргүүтнийг эцэг, гол мөрөн тэргүүтнийг эх хэмээн тахин шүтэж, хайрлан хамгаалж ирсэний гэрч болж байна.

2. Баянхангайн баялгийг танин мэдээд, зүйл зүйл утга төгөлдөр нэр хайрласан байна.

- Ан амьтан нутагшсанаар нь: Туулайт, Үнэгт, Бугат, Хандгайт, Ангирт гол, Галуут нуур, Тахийн ус (баянбүрд), Тарвагатай гэх мэт.

- Өвс ургамал ургаснаар нь: Нарст өндөр (Дорнод), Бургаст, Хайлааст, Агит, Яргайт, Улиастай гэх мэт.

- Эрдэс бодис элбэгээр нь: Чулуут, Цахиурт, Эрдэнэт, Оюу толгой, Алтан, Зост, Билүүт, Шаварт гэх мэт.

3. Баянхангай, газар дэлхийн шинжийг танин мэдэж, сэтгэн дүрсэлсэн нэр хайрласан байна.

• Газар, усны тогтоц хэлбэр дүрсийг зүйрлэн нэрлэсэн: Майхан толгой, Дөш толгой, Дэл уул, Суваргахайрхан, Сэнжит, Төгрөг нуур, Дөрвөлжин нуур, Олгой нуур, Соёо нуур, Мэлхий хад гэх мэт.

• Газар, усны байршил, овор төрх, зүг чигийн мэдлэгээр нэрлэсэн: Архангай, Өвөрхангай, Дунд гол, Зүүн баян, Баруун бүрхийн нуруу, Их уул, Бага уул, Олон нуур, Нам даваа, Өндөрхайрхан, Өргөн ширэг, Нарийн гол гэх мэт.

• Байгалийн өнгө байдлаар нь нэрлэсэн: Цагаан нуур, Хөх нуур, Бор нуур, Улаан нуур, Хар нуур, Шар нуур, Цэгээн нуур, Буурал уул, Алаг уул, Эрээн нуур, Хар хад, Шар хад, Цахир хад, Улаан хад, Хүрэн хад, Загал уул, Хонгор уул, Алаг өндөр гэх мэт.

• Газар, усандаа үнэлэмж нэр өгсөн нь: Бүлээн нуур, Дулаан уул, Хүйтэн уул, Гашуун нуур, Бэрх уул, Салхит, Сэрүүн даваа, Түргэн гол, Цаст уул, Мөст, Хонгион гол (Ховд, Эрдэнэбүрин сум, Үргэлж салхилан шуугиж байдаг учир буугийн хонгиотой адилтгаж нэрлэсэн гэдэг)

4. Баянхангай, газар нутаг, гол мөрөн тэргүүтнээ бэлгэ чанарын өргөмж нэр хайрласан байна. Буянт гол, Номхон далай, Амгалант гол, Асралтхайрхан, Ачит нуур, эргэн уул, Өлзийт гол, Дөлгөөн нуур, Жаргалант хайрхан гэх мэт. Мөн Сайхан уул (Булган), Уран гол (Хөвсгөл), Мөнхнаст (Баян-Өлгий) гэх мэт нэр нутаг нугаа дээдэлсний илрэл юм.

5. Сав, шим ертөнцийн мөнхийн холбоог танин мэдэж, ялангуяа, амьтны нэр оролцуулан нэрийдсэн оноосон нэр элбэг байна. Жишээ нь: Азаргын гол, Ат нуур (Увс), Буур нуур, Бух гол, Арвайхээрийн тал, Хонин ус, Хуц хайрхан гэх мэт.

Монгол газар, усны нэрийн дотор гарал үүсэл, үгийн бүтэц, утгыг хойшид нарийвчилан судалмаар оноосон нэр цөөн бус байна. Жишээлбэл: Аргуй гол, Бүтсэй гол, Арсай гол, Сагсай гол, Онон гол, Туул гол, Орхон гол, Хэрлэн гол, Завхан гол, Байдраг гол, Атасбогд, Бужир уул, Буянай уул, Цуврай уул гэх мэт.

Монгол газар, усны нэрийдэл бүтээдэг бүтээц бүхий давтамжтай дагавар гэвэл:

- в, - г, - гар (- гэр, - гор, - гөр), - даг (- дэг, - дог, - дөг), - дай (- дэй, -дой), -р, -с (- сун, - сүн), - т (- тай, - тэй), -хан (- хэн), - цаг (- цэг, - цог, цөг) гэх мэт дагавар байна.

Монгол газар, усыг танин мэдэж, баялаг, тогтоц, өнгө, байгалийн шинж зэргээр нь нэрийдсэн нийлмэл нэр өргөн дэлгэр байна гэж дүгнэн хэлж болно.

НОМЗҮЙ

1. Бадамдорж Д (1997), *Монгол хэлний нэр дэвсгэрлэх ёсон*, МУИС, Монгол судлалын дээд сургууль, ЭШБ. № 9 (126).
2. Бадамдорж Д (2006), *Монгол хэлний үгийн сангийн утгазүй*, Улаанбаатар.
3. Болд Л (1986), *Орчин цагийн монгол хэлний дагавар*, Редактор Ц.Цэдэндамба, Улаанбаатар.
4. Бондалетов В.Д (1983), *“Русская ономастика”*, Москва. Стр. 163.
5. *“Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”*, Таван боть (2008), Анхдугаар хэвлэл, Ерөнхий редактор Л.Болд, А-Г. Улаанбаатар, 364 дэх тал.

6. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”, Таван боть (2008), Таван боть, Х-Я.Ерөнхий редактор Л.Болд. Улаанбаатар, 2742 дахь тал.
7. “Монголын нэвтэрхий толь” (2000), Ерөнхий редактор академич Б.Чадраа I, А-М, Улаанбаатар, 399 дэх тал.
8. Намсрай Н (1969), *Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын газар нутгийн нэрс*, Урд хас ус 3-18, 25 дахь тал.
9. Норжин (2001), *Монгол хэлний үг бүтээх дагаврын хураангуй*, Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, Хөх хот. 168 дахь тал.
10. Равдан Э. (2004), *Монголын газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа*” Улаанбаатар, 55, 222-259 дэх тал.
11. Равдан Э (2006), *Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь*. Улаанбаатар, Боть I. (XX зууны 30-40 он) 203 дахь тал.
12. Равдан Э (2008), *Монгол орны газар нутгийн нэр зүй*, Улаанбаатар, 29, 202-203, 359 дэх тал.
13. Сүхбаатар О (2001), *Монгол газар усны нэрийн домог*, Улаанбаатар, 23 дахь тал.
14. Төмөрцэрэн Ж (2001), *Монгол хэлний үгийн сангийн судлал*, Улаанбаатар, 97 дахь тал.
15. Шагдар Ш (1978), *Монголын газар зүйн нэрийн товч толь бичиг*, Улаанбаатар, 24, 30 дахь тал.
16. Шагдарсүрэн Ц (2003), *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 12 дахь тал.
17. Шулунова Л.В (1995), *Ономастика прибайкалья*, Улан-Удэ. Стр 141.

SUMMARY

In this article, the author analyzed suffixes, which express the land as a part of Mongolian lexicology. Suffixes such as;

- γar (- ger, - γor, - гγr), - day (- deg, -doγ, - dγg), - dai (- dei, - doi, -dцi), - r, - s, - t, -qan (- ken, - qon, - kцn), - čay (- čeg, - čoy, čug) are enormously repeated. But some suffixes from several words and their repetition is not too much in their usage.